



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 4/11

Бор-Өндөр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орд овогтой Чамин-чулуунтай "Бумбат 3 дугаар багийн нутаг дэвсгэрт ногоон байгууламжийн хойд хэсгийн хашаажуулалт"-ын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан тул Засаг даргын Тамгын газрын байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 10.000.000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Санхүүжилтэд зарцуулагдах 10.000.000 (арван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

З.УУГАНЖАРГАЛ

